

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тэсэлгээний ажил гүйцэтгэх ажлын даалгавар

Гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөл, ажлын төлөвлөгөө, захиалагч талын чиглэл зааварчилгаа болон ХАБЭА, БО-ны стандарт, дүрэм журам, “Тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хууль дүрэм”, Баянтээг Хувьцаат Компанийн дүрэм журам, холбогдох хууль тогтоомж, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2-р багт байрлах “Баянтээг” чулуун нүүрсний ордын хөрсний чулуулгат стандартын шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, дэвшилтэт технологиор тэсэлгээнмэргэжлийн өндөр түвшинд аюул осолгүй, бутлан сийрэгжүүлэх ажил хийж гүйцэтгэнэ.

Хийгдэх ажил

1. Гүйцэтгэгч нь тэсэлгээний ажлын жишиг төсөл, тухайлан тодорхой нөхцөлд гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын зураг төсөл боловсруулж мөрдөж ажиллана. Жишиг төслийг тухайн ашигт малтмалын ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, туршилт болон үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн судалгаа, ижил, тэстэй нөхцөл дэх үйлдвэрлэлийн тэсэлгээний ажлын туршлага бололын туршлага болон “Тэсэлгээний аюулгүй ажиллааганы нэгдсэн дүрэм”ийн шаардлагад үндэслэн боловсруулна.
2. Гүйцэтгэгч нь тухайн төсөлд дараах шийдлүүдийг тусгасан байна.
 - 2.1 тэсэлгээний ажлын үндсэн хэмжээсүүд
 - 2.2 цэнэгийг өдөөх арга
 - 2.3 тэсэлгээний хэлхээний /дараалал, удаашралын хугацаа/ тооцоо
 - 2.4 цэнэгийн бүтэц, бүүстрийн байрлал
 - 2.5 тэсрэх материалын зарцуулалтын тооцоо
 - 2.6 тэсэлгээний нөлөөллийн хүрээнд байрлах объектын /барилга, байгууламж, шугам хэлхээ/ аюулгүй байдлыг хангах аюултай бүсийн тооцоо, хамгаалах арга
 - 2.7 Тэсэлгээний бүсийг агааржуулах болон энэхүү дүрэмд заасан аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээг зааж, тэсэлгээний ажил болон холбогдох бусад бүхий л шаардлагатай ажлуудыг аюулгүй зохион байгуулах шийдлийг тусгасан байна.
3. Гүйцэтгэгч уурхайд тэсэлгээний ажлыг явуулах ба бутлагдлын дундаж хэмжээг 0,7 метрээс ихгүй болгож бутлан сийрэгжүүлэх үүргийг хүлээнэ.
4. Тэсэлгээний ажлыг уурхай дээр гүйцэтгэгч нь ажил үүргээ аюул осолгүй, технологийн горимын дагуу хэвийн явуулах машин тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна. Цооног цэнэглэх ажлыг зөвхөн зориулалтын машинаар хийж гүйцэтгэнэ.

Цооногийн тоо		Нийт тууш метр	Уулын цул / м ³ /
Устай	Усгүй	3510	70200
112	239		

Тэсэлгээний ажлын паспорт

